



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 4/57

Улаанбаатар хот

Хуралдаан хуралдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдааныг 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 9<sup>00</sup> цагт хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1 Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

1.2 Дүүргийн 2019 оны батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай Баянхошуу, Сонгинохайрхан уулын хилийн цэст өөрчлөлт оруулах тухай

2. Хуралдааныг зохион байгуулахад шаардлагдах зардлыг тооцож, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны төсвийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Н.Мөнхбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Хуралдааны бэлтгэлийг зохион байгуулалтын өндөр түвшинд хангаж ажиллахыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Н.Мөнхбаатар/, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Төмөрбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.



Б.МӨНХЦЭЦЭГ